

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТАЙШИР СУМЫН НУТАГТ
БАЙРЛАХ “ХОС КВАРЦ” ХХК-ИЙН “ХӨШӨӨТИЙН
САЙРЫН АЛТНЫ ШОРООН ОРДЫН “ХШ-6-ХШ-14”-ИЙН
ХООРОНД ДАХЬ НӨӨЦИЙГ ИЛ АРГААР АШИГЛАХ”
ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**



2026 он

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ	3
1.1. Байгууллагын мэдээлэл	3
1.5. Дэд бүтэц	5
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ БҮС НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТОДОРХОЙЛОЛТ	8
2.1. Байгаль орчны онцлог	8
2.2. Нийгэм эдийн засаг	8
3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ.....	10
3.1. Газрын гадарга, хэвлий.....	10
3.2. Агаарын чанар.....	10
3.3. Хөрсөн бүрхэвч	10
3.4. Гадаргын болон газрын доорх ус.....	11
3.4. Ургамлан нөмрөг.....	12
3.5. Амьтны аймаг	12
3.6. Нийгэм эдийн засаг	12
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	14
4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ	15
4.2. Нөхөн сэргээлт, хаалтын ажлын төлөвлөгөө	18
4.3. Дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөө	18
4.4. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	18
4.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	19
4.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	19
4.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	20
4.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	22
4.9. Байгаль орчны удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө.....	25
4.10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээний төлөвлөгөө	26
ДҮГНЭЛТ	27

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн өнөөгийн байдал	3
Зураг 2. Төслийн талбайн байршлын зураг (ArcGis 10.8)	4
Зураг 3. Төсөл хэрэгжих талбайн өнөөгийн байдал	4
Зураг 4. Мониторингийн цэгийн байршлын зураг	24

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Лицензийн талбайн газарзүйн солбилцол	3
Хүснэгт 2. Ил уурхайн ажиллах горим	5
Хүснэгт 3. Барилга, байгууламжийн мэдээлэл	5
Хүснэгт 4. Тооцооны бүрэн цахилгаан ачаалал	6
Хүснэгт 5. Ундны ус ашиглалтын тооцоо	6
Хүснэгт 6. Баяжуулах үйлдвэрийн усны хэрэглээ	6
Хүснэгт 7. Ногоон байгууламж, зам талбайн ус ашиглалтын тооцоо	7
Хүснэгт 8. Биологийн нөхөн сэргээлтэд ашиглах усны хэмжээ	7
Хүснэгт 9. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлт	9
Хүснэгт 10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал	14
Хүснэгт 11. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	15
Хүснэгт 12. Нөхөн сэргээлт, хаалтын ажлын зардал	18
Хүснэгт 13. Дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөө	18
Хүснэгт 14. Орчны тохижилт, ногоон байгууламжийн төлөвлөгөө	18
Хүснэгт 15. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	19
Хүснэгт 16. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	19
Хүснэгт 17. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	20
Хүснэгт 18. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр/Олборлолтын өмнө /	23
Хүснэгт 19. Орчны хяналт шинжилгээний цэгийн байршил	24
Хүснэгт 20. Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө	25
Хүснэгт 21. БОМТ хэрэгжилт тайлагнах арга хэмжээний төлөвлөгөө	26

1. ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ

1.1. Байгууллагын мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч: “Хос Кварц” ХХК
Улсын бүртгэлийн дугаар: 9011575042
Регистрийн дугаар: 6014801
Хаяг: Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7-р хороолол, ногоон нуур
Холбоо барих утас: Утас: 99111488

1.2. Төслийн зорилго

Ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийг үндэслэн Говь-Алтай аймгийн Тайшир сумын нутагт орших Мөрөн нэртэй газар орших 244.53 га талбайг хамарсан MV-022420 дугаар бүхий тусгай зөвшөөрлийг “Хос кварц” ХХК эзэмшдэг.

“Хос кварц” ХХК нь MV-022420 тоот ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл бүхий талбайд батлагдсан алтны шороон ордын нөөцийг бүрэн дүүрэн ашиглах, цаашид ашиглалтын үед хайгуулын ажил хийн ордын нөөц өсөх эсэхийг тогтоох зорилт тавин ажиллаж байна. Уг зорилтын хүрээнд “Хос кварц” ХХК-ийн “Хөшөөтийн сайрын ордын “ХШ-6-ХШ-14”-ийн хооронд дахь алтны шороон ордыг ил аргаар ашиглах” техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан байна.

1.3. Талбайн байршил


Орд нь Улаанбаатар хотоос баруун тийш 1020 км орчим, Алтай хотоос зүүн урагш 18 км, Тайшир сумын төвөөс зүүн урагш 63 км зайтай оршино.

Хүснэгт 1. Лицензийн талбайн газарзүйн солбилцол


№	ЗУ	ХӨ	Талбайн хэмжээ, га
1	96° 28' 32.14" E	46° 17' 34.94" N	244.53 га
2	96° 27' 14.14" E	46° 17' 33.21" N	
3	96° 27' 14.14" E	46° 18' 21.51" N	
4	96° 28' 53.9" E	46° 17' 57.7" N	



Зураг 1. Төслийн талбайн өнөөгийн байдал



Зураг 2. Төслийн талбайн байршил (ArcGis 10.8)



Зураг 3. Төсөл хэрэгжих талбайн өнөөгийн байдал

1.4. Төслийн хүчин чадал

Дээрх нөөцөд тулгуурлан ордыг ил аргаар, гадаад, дотоод овоолготой, автотээвэртэй ашиглалтын системээр ашиглана. Төслийн хүчин чадал 52.2 мян.м³/жил элс бөгөөд төсөл хэрэгжих хугацаа 1 жил буюу 2 сар байна.

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТАЙШИР СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ХӨШӨӨТИЙН САЙРЫН АЛТНЫ ШОРООН ОРДЫН “ХШ-6-ХШ-14”-ИЙН ХООРОНД ДАХЬ НӨӨЦИЙГ ИЛ АРГААР АШИГЛАХ” ТӨСӨЛ

Хөшөөтийн сайрын ордын үйлдвэрлэлийн нөөцийг 2 сарын хугацаанд олборлох бөгөөд ажиллах боломжит 61 хоногоос дараах хугацааг хорогдуулан уурхайн жилд ажиллах цэвэр хугацааг тооцсон. Үүнд:

- Уурхайн бэлтгэл ажил 10 хоног;
- Цаг агаарын саатал 3 хоногийг хасч тооцсоноор уурхайн жилд ажиллах цэвэр хугацааг 48 хоног байхаар тооцлоо.

Уурхай нь хоногт 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байх бөгөөд цайны цаг, ээлжийн бэлтгэл төгсгөл цаг зэргийг хасч тооцсоноор ээлжинд ажиллах цэвэр хугацаа 10 цаг байхаар тооцлоо. Уурхайн ээлжийн цаг ашиглалтын коэффициент 0.83 жилд 960 цаг ажиллах хязгаартай байна.

Хүснэгт 2. Ил уурхайн ажиллах горим

№	Үзүүлэлт	Х.нэгж	Хэмжээ
1	Ажиллах боломжит хугацаа	хоног	61
2	Бэлтгэл ажил	хоног	10
3	Цаг агаарын саатал	хоног	3
4	Ажиллах хугацаа	хоног	48
5	Хоног дахь ээлжийн тоо	Ээлж/хон	2
6	Ээлжийн үргэлжлэх хугацаа	Цаг	12
7	Ээлжийн цаг ашиглалтын коэффициент		0.83
8	Ажиллах ээлжийн тоо	Ээлж/жил	96
9	Ажиллах цаг	Цаг/жил	960

1.5. Дэд бүтэц

Уурхайн барилга байгууламж: Уурхайн кемпийг тусгай зөвшөөрлийн талбайд, ХШ-6-аас зүүн зүгт ойролцоогоор 200 метрийн зайнд байгуулна. Төслийн хугацаа богино тул зөөврийн байдлаар барилга байгууламжыг төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Барилга, байгууламжийн мэдээлэл

№	Барилгын нэр	Тоо ширхэг	Талбайн хэмжээ, м ²	Нийт талбай, м ²	Зориулалт	Бүтээц эдлэл
Хотхон						
1	Зөөврийн сууц-1	1	20	20	Уурхайн удирдлагын байр	Тохижуулсан контейнер
2	Зөөврийн сууц-2	1	40	40	Гал тогоо	Тохижуулсан контейнер
3	Зөөврийн сууц-3	1	28	28	Душ	Тохижуулсан контейнер
4	Зөөврийн сууц-4	3	28	84	Ажилчдын амрах байр	Тохижуулсан контейнер
Ил уурхай						
5	Зөөврийн сууц-5	1	12	12	Харуулын байр	Тохижуулсан контейнер

Уурхайн зам: Уурхайн үйлдвэрлэлийн болон аж ахуйн зам нь хоёр урсгалтай байна. ТЭЗҮ-д замын норм дүрмийн дагуу хоёр урсгалтай замын зорчих хэсгийн өргөнийг ОХУ-ын эрдэмтэн М.В.Васильев, проф А.В.Андреев нарын арга болон замын зэрэглэл, зорчих хэсгийн зурвасын тоо, автосамосвалын хөдөлгөөний хурд, даацын нөхцөлөөс хамаарсан хамгийн бага өргөнг тооцох баримтлал зэргийг харьцуулсны эцэст зорчих хэсгийн өргөнийг тодорхойлсон байна.

Замын зорчих хэсгийн өргөнийг хурдны нөлөөлөл тооцох коэффициент ашиглан дараах томъёогоор тооцсон байна. Хөдөлгөөний нэг зурвастай замын зорчих хэсгийн өргөн (м).

$$Ш_1 = a + 2y;$$

$$Ш_1 = 2.5 + 2 \cdot 0.5 = 3.5 \text{ м};$$

Үүнд:

a - автосамосвалын өргөн, м

y – нөөц буюу хажуугийн зурвасын өргөн, 0.5 мм

Цахилгаан хангамж: Цахилгаан хэрэглэгчид: Ашиглалтын туршид цахилгаан эрчим хүч хэрэглэх цахилгаан хэрэглэгчдийн цахилгаан ачаалал, тэдгээрийн цахилгаан эрчим хүчний зарцуулалтыг тооцов. Уурхайн ашиглалтын үед цахилгааны дараах үндсэн хэрэглэгч байна. Үүнд:

- Уурхайн кемпийн хэрэглэгчид: Уурхайн захиргаа аж ахуйн байр, ажилчдын байр, цайны газар;
- Баяжуулах хэсэг: Скруббер, насос, тунаах ширээ, гэрэлтүүлэг;
- Бусад хэрэглэгчид: Засварын газар, ШТС;

Гадаад цахилгаан хангамж: Төвийн эрчим хүчний системт холбогдоогүй байна. Уурхайн цахилгааны хэрэглээ бага, ашиглалтын хугацаа богино зэргийг үндэслэн дизель генератор ашиглахаар төсөлд тооцсон байна.

Дотоод цахилгаан хангамж: Харин уурхайн дотоод цахилгаан хангамжийн хувьд барилга байгууламжуудын байршил, зайнаас хамаарч уурхайн кемп тусдаа, баяжуулах хэсэг болон засварын хэсгүүд нэг дизель генератороос тэжээл авахаар тооцсон байна.

Хүснэгт 4. Тооцооны бүрэн цахилгаан ачаалал

№	Цахилгаан хэрэглэгчид	Тооцооны актив чадал, кВт (Pт)	Тооцооны реактив чадал, кВАр (Qт)	Тооцооны бүрэн цахилгаан ачаалал, кВА (St)
1	Баяжуулах хэсэг	62.3	30.1	69.2
2	Засварын газар, сэлбэг хэрэгслийн агуулах	10.9	5.1	12.0
3	Уурхайн тосгон	17.8	6.4	18.9
Нийт дүн		91.0	41.6	100.2

Унд ахуйн усны хэрэглээ: Уурхайн ус ашиглалтын хэмжээг дараах хүснэгтэд БОНХАЖСайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалаар батлагдсан Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны нормын дагуу тооцоолов.

Хүснэгт 5. Ундны ус ашиглалтын тооцоо

№	Ус ашиглах эх үүсвэр	Тоо хэмжээ	Норм, литр	Хугацаа /хоног/	Ус хэрэглээ, м³/хоног	Ус хэрэглээ, м³/жил
1	Унд ахуйн хэрэглээ	44	80 л/хон/хүн	61	3.52	214.72

Уурхай болон баяжуулах үйлдвэр нь нийт 2 сарын хугацаанд үйл ажиллагаа явуулна.

Технологийн усны хэрэглээ: Баяжуулах технологийн усны үүсвэрийг гүний уснаас насосаар татаж, угаалгын ажлын эхэнд нийт шаардагдах усаар 100% хангаж өгөх ба цаашид 75%-ийг эргүүлэн ашиглана. Үлдсэн 25%-ийг цэвэр усаар хангана. Угаан баяжуулах үйлдвэр нь төслийн нийт хугацаанд 51 хоног ажиллах бөгөөд 1 хоногт 20 цаг ажиллахаар төлөвлөсөн. Баяжуулах үйлдвэр нь сард 30 мян.м³ элс угаах бол 1 цагт зарцуулах технологийн усны хүчин чадал 300 м³/цаг байна.

Хүснэгт 6. Баяжуулах үйлдвэрийн усны хэрэглээ

№	Хугацаа	Норм, м³	Угаах элсний хэмжээ м³/хон	Цэвэр ус м³/цаг	Усны насос, хүчин чадал м³/цаг	Хоногийн ус ашиглалт, м³	Ус ашиглалт, м³	
							Дахин дүүргэлтээр ашиглах ус /75%/	Цэвэр ус /25%/
1	1 сард	4	1,000	60	300	4,000	3,000	1,000

Сард 30 мян.м³ элсийг угаахад нийт 120,000 м³ ус шаардлагатайгаас хоногт 4,000 м³ ус ашиглах ба цаашид хоногт нийт хэрэгцээний 75%-ийг эргэлтийн уснаас буюу 3,000 м³ усыг эргэлтийн усаар, 25%-ийг цэвэр уснаас буюу 1,000 м³ цэвэр усаар хангахаар байна. Иймд төсөл хэрэгжих 2 сарын хугацаанд нийт 54,000 м³ цэвэр ус ашиглахаар байна.

Зам талбай, ногоон байгууламжын усны хэрэглээ

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТАЙШИР СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ХӨШӨӨТИЙН САЙРЫН АЛТНЫ ШОРООН ОРДЫН “ХШ-6-ХШ-14”-ИЙН ХООРОНД ДАХЬ НӨӨЦИЙГ ИЛ АРГААР АШИГЛАХ” ТӨСӨЛ

Хүснэгт 7. Ногоон байгууламж, зам талбайн ус ашиглалтын тооцоо

№	Ус ашиглах эх үүсвэр	Тоо хэмжээ	Норм, литр	Шаардлагатай усны тооцоо, м³/хон	Шаардлагатай усны тооцоо, м³/жил
1	Тэрбум мод	1,200 ш	40 л	4	128
	Зам, талбайн усалгаа/нийт зам/	1,350 м²	2 л	2.7	54
Нийт ус ашиглалтын хэмжээ, м³				6.7	182

Зам талбайн усалгааг төслийн хугацаанд 20 хоног услана.

Ногоон байгууламжыг 7 хоногт 4 удаа буюу төслийн хугацаанд 32 удаа услахаар тооцов.

Биологийн нөхөн сэргээлтэд ашиглах усны хэмжээ

Уурхайн үйл ажиллагаанаас эвдэрсэн газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийнэ. Уг уурхайн олборлолтын талбай болон уурхайн суурин зам талбай, овоолгын улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээнэ. Биологийн нөхөн сэргээлтэд тарьсан ургамлыг услах зориулалтаар ус ашиглана. Биологийн нөхөн сэргээлтийг нийт 5.8 га газарт хийнэ.

Нөхөн сэргээлтэд зарцуулагдах усыг БОНХАЖ-ын сайдын 2015 оны А/301 тоот тушаалаар батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-ын 13 дугаар хавсралтын дагуу олон наст ургамлаар нөхөн сэргээсэн талбайг 4 л/м² нормоор услахаар тооцлоо.

Хүснэгт 8. Биологийн нөхөн сэргээлтэд ашиглах усны хэмжээ

Ус хэрэглээний зориулалт	Нийт талбай, га	Сэлгэлтээр хоногт услах талбай, га	Норм, л	Услах тоо	Ус хэрэглээ, м³	
					Хоногт	Жилд
Ургамалжуулсан талбайг услах	5.8	0.1	4	12	4	192

Нийт ус хэрэглээ

- Унд-ахуйн хэрэгцээнд:
Ил уурхай болон баяжуулах үйлдвэр 44 хүн х 80 л/хон = 3.52 м³/хон (214.72 м³/жил)
- Зам, талбайн усалгааны хэрэгцээнд:
100 ширхэг х 40 л = 4 м³/хон (192 м³/жил)
1,350 м² х 2 л = 2,7 м³/хон (54 м³/жил)
- Биологийн нөхөн сэргээлтийн хэрэгцээнд:
0.1 га /сэлгэлтээр/ х 4 л/м² = 4 м³/хон (192 м³/жил)
- Угаан баяжуулах үйлдвэрийн хэрэгцээнд
4000*75%=1000 хоногийн усны хэрэглээ
1000*4м³=4000*51хон=204,000*25%=51,000м³/жил

Нийт төслийн ус ашиглалт 1014.22 м³/хон (51,652.72м³/2 сар) ус шаардагдана.

Иймд гүний худаг 1, 2 усны ундрага нь нийт 34л/сек буюу:

1 цагт – 122,4 м³

1 хоногт – 2,937.6 м³

Төслийн хугацаанд – 149,817.6 м³ ус ундрахаар байна.

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ БҮС НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Байгаль орчны онцлог

Төслийн талбайн хилийн вектор өгөгдлийг газарзүйн мэдээллийн системд оруулахад Говь-Алтай аймгийн Тайшир сумын Галуут багын нутагт нийт 244.53 га талбайд алтны шороон орд нь Улаанбаатар хотоос баруун тийш 1020 км орчим, Алтай хотоос зүүн урагш 18 км, Тайшир сумын төвөөс зүүн урагш 63 км зайтай оршино.

Төсөл хэрэгжих талбай нь физик газарзүйн мужлалаар Монголын Алтайн их мужийн Говь-Алтайн нурууны тойрогт багтана. Тус бүс нутаг нь өндөр уул, уулс хоорондын хөндий, голын хөндий, ухаа толгод зонхилсон уулын хэв шинжтэй. Говь-Алтай аймаг-ийн баруун болон төв хэсгийг хамрах энэ бүсийн дундаж өндөр далайн түвшнээс дээш 1,500–2,500 м бөгөөд зарим оргилууд 3,000 м-ээс дээш өргөгдөнө.

Судалгааны талбай нь Тайшир сум-ын нутаг дэвсгэрт байрладаг. Говь-Алтай аймаг нь эх газрын эрс тэс, хуурай уур амьсгалтай бөгөөд нутгийн ихэнх хэсэг нь хуурай хээр, цөлөрхөг хээрийн уур амьсгалын бүсэд хамаардаг. Уур амьсгалын хувьд зундаа агаарын температур +28°C–+34°C хүрч халдаг бол өвөлдөө -28°C–35°C хүртэл хүйтэрдэг. Жилийн хур тунадасны хэмжээ дунджаар 100–180 мм бөгөөд хур тунадасны ихэнх нь зуны улиралд ордог.

2.2. Нийгэм эдийн засаг

Говь-Алтай аймгийн Тайшир сум нь мал аж ахуй давамгайл хөгжсөн, хүн амын нягтаршил багатай хөдөөгийн сум юм. Үндэсний статистикийн хорооны 2024 оны жилийн эцсийн мэдээгээр тус сум 1,779 хүн амтай, 600 орчим өрхтэй байна. Хүн амын тоо сүүлийн жилүүдэд аажмаар буурах хандлагатай байгаа бөгөөд 2022 онд 1,805 хүн, 2023 онд 1,792 хүн, 2024 онд 1,779 хүн бүртгэгдсэн нь гурван жилийн хугацаанд нийт 26 хүнээр буюу 1.4 хувиар буурсан үзүүлэлт юм.

Тайшир сумын эдийн засгийн гол тулгуур салбар нь мал аж ахуй бөгөөд хүн амын дийлэнх нь хонь, ямаа, үхэр, адуу, тэмээ маллан амьжиргаагаа залгуулдаг. Мал аж ахуйгаас гадна төрийн байгууллага, боловсрол, эрүүл мэнд, худалдаа үйлчилгээний салбарт ажиллагсад хөдөлмөр эрхэлдэг. Үйлдвэрлэл, уул уурхайн томоохон аж ахуйн нэгж харьцангуй цөөн тул байнгын ажлын байр хязгаарлагдмал бөгөөд хөдөлмөрийн насны иргэдийн тодорхой хэсэг нь улирлын чанартай болон бусад бүс нутагт шилжин ажиллах хандлагатай байдаг.

Боловсрол: Суманд ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв ажиллаж, боловсрол болон анхан шатны эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлдэг. Нарийн мэргэжлийн эмнэлгийн тусламжийг Говь-Алтай аймгийн төвөөс авдаг. Цахилгаан эрчим хүч, үүрэн холбоо, интернетийн үйлчилгээтэй бөгөөд аймгийн төвтэй авто замаар холбогдсон.

Нийгмийн дэд бүтэц, хүн амын тархалт: Амьжиргааны бүтэц нь байгалийн нөөц, бэлчээр, усны эх үүсвэртэй нягт холбоотой байдаг. Иймээс уул уурхайн төсөл хэрэгжих үед бэлчээрийн ашиглалт, малын усан хангамж, замын хөдөлгөөн, тоосжилт, дуу чимээ зэрэг хүчин зүйлс нь орон нутгийн иргэдийн амьдралд хамгийн их нөлөөлөх эрсдэлтэйд тооцогдоно.

Нөгөө талаас төсөл хэрэгжсэнээр орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах, орон нутгийн ханган нийлүүлэгчдээс бараа, үйлчилгээ худалдан авах, орон нутгийн төсөвт татвар, хураамжийн орлого төвлөрүүлэх зэрэг эерэг үр нөлөө бий болох боломжтой. Иймд төслийн хэрэгжилтийн явцад орон нутгийн иргэдийн оролцоог хангах, байгаль орчны хамгаалалт, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, нийгмийн хариуцлагын арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх нь төслийн нийгмийн эерэг үр өгөөжийг нэмэгдүүлэх чухал нөхцөл болно.

Нөлөөллийн үнэлгээ нэгтгэл:

“Хөшөөтийн сайрын алтны шороон ордын “ХШ-6–ХШ-14”-ийн хооронд дахь нөөцийг ил аргаар ашиглах” төслийн байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл нь голчлон шимт хөрс хуулалт, элс олборлолт, баяжуулах, тээвэрлэлтийн үйл ажиллагаа, уурхайн машин, механизмын ашиглалт, шатахуун, тослох материалын хадгалалт, ашиглалт зэрэг түүнтэй холбоотой эрсдэлээс үүдэхээр байна.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг агаар, ус, хөрс, биологийн олон янз байдал болон хүн ам, нийгмийн орчин зэрэг байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр нарийвчлан үнэлж, нийт 45 болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлсон. Үүнээс 6 буюу 16.3 хувь нь бага, 28 буюу 62.2 хувь нь дунд, 11 буюу 24.5 хувь нь их сөрөг зэргийн нөлөөллийн түвшинд хамаарагдаж байна.

Үнэлгээний дүнг нэгтгэн авч үзвэл, төслийн хүрээнд хэрэгжих үйл ажиллагаанууд нь байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд дунд хэмжээний сөрөг нөлөөлөл үзүүлэх эрсдэлтэй бөгөөд зохих урьдчилан сэргийлэх, хяналт-менежментийн арга хэмжээг хэрэгжүүлснээр сөрөг нөлөөллийг бууруулах боломжтой гэж дүгнэж байна.

Хүснэгт 9. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлт

№	Байгаль орчны бүрэлдэхүүн	Бага	Дунд	Их	Нийт үнэлгээ
1	Газрын гадарга, газрын хэвлий	-	4	2	6
2	Агаарын чанар	-	4	2	6
3	Усан орчин	2	4	-	6
4	Хөрсөн бүрхэвч	-	5	3	8
5	Ургамлан нөмрөг	-	2	4	6
6	Амьтны аймаг	2	3	-	5
7	Хүний эрүүл мэнд	2	6	-	8
	Нийт	6	28	11	45
	Нийт эзлэх хувь	16.3%	62.2%	24.5%	100%

3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

3.1. Газрын гадарга, хэвлий

“Хос кварц” ХХК-ийн хэрэгжүүлж буй төсөл нь Говь-Алтай аймгийн Тайшир сумын нутагт MV-022420 ашиглалтын тусгай зөвшөөрлийн 224.53 га талбайг хамран байрлана. Цаашид ашиглалтын 2 сарын хугацаанд уурхайн үйл ажиллагаанаас нийт 7.2 га талбай уурхайн нөлөөлөлд өртөж, эвдрэлд орохоор байна.

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

- Газар шорооны ажлыг шимт хөрс хуулалт, хадгалалтад MNS 5916:2008 стандартыг мөрдөж ажиллах
- Уурхайн шимт хөрсийг хуулж, зонхилох салхины чиглэл дагуу нуруулдан, овоолгын гадаргуугийн налууг 18 градусаас ихгүйгээр, хажуугийн налууг 25 градусаас ихгүй байхаар налуулан байгуулах,
- Уурхайн үйл ажиллагаа 2 сарын хугацаанд үргэлжлэх тул шимт хөрсийг богино хугацаанд хөрсний бичил биет устахгүй байхаар хадгалах
- Шимт хөрсийг 2-3м, нам урт хэлбэртэй, карьерээс гадна, усанд автахгүй өндөрлөг газар хадгалах
- Шимт хөрсийг овоолсны дараа гадаргууг өвсөөр хучих нь богино хугацаанд шимт хөрсний чийгийг хадгалах давуу талтай.

3.2. Агаарын чанар

Ил уурхайн үйл ажиллагаа нь 2 сарын хугацаанд үргэлжлэх тул агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл харьцангуй дунд түвшинд байна. Төслийн олборлолт, тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас бий болох тоос тоосонцор, дуу чимээ, тээврийн хэрэгслээс ялгарах хорт хий зэргийн ялгарлын тооцооллын дүнгээр төслөөс жилд ордын олборлолт, тээвэрлэлт болон бусад үйл ажиллагаа явагдаж байгаа хэсгийн дундаж агууламж 476 мкг/м^3 буюу MNS 4585:2025 стандартын нийт тоосны жилийн дундаж хүлцэх агууламж болох 100 мкг/м^3 хэмжээнээс 4.8 дахин, PM10 тоосонцрын агууламж 128 мкг/м^3 буюу жилийн дундаж хүлцэх хэмжээ 50 мкг/м^3 агууламжаас 4 дахин, PM2.5 тоосны агууламж 45 мкг/м^3 буюу жилийн дундаж хүлцэх хэмжээ 25 мкг/м^3 агууламжийн хэмжээнээс 1.8 дахин их тоосжилт үүсгэн 823 га талбайг хамран тархаж орчны агууламжийг нэмэгдүүлэн жилийн турш эрчимтэй явагдах тул төслийн турш дараах бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлж байх шаардлагатай.

3.3. Хөрсөн бүрхэвч

“Хөшөөтийн сайрын ордын “ХШ-6-ХШ-14”-ийн хооронд дахь алтны шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн үйл ажиллагаанаас 7.2 га орчим талбай эвдрэлд өртөж хөрс доройтно. Иймд төслөөс хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Хог хаягдлын төвлөрсөн цэгийг зохих стандартын дагуу барих шаардлагатай.
- Хог хаягдлын цэгийн суурийг бетонон хучилттайгаар буюу хөрсөнд бохирдол нэвчихгүй байдлаар төлөвлөх
- Хог хаягдлын цэгт хуримтлагдсан хог хаягдал болон бусад шингэн хаягдлыг хур борооны усаар зөөгдөхгүй байхаар төлөвлөх
- Ногоон байгууламжийг нэмэгдүүлж, байнгын арчилгаатай байлгах
- Тухайн талбайд хүнд элементийн бохирдол илрээгүй боловч цаашдын үйл ажиллагааны үед санаатай болон санамсаргүй байдлаар хөрсийг бохирдуулж болзошгүй. Хэрэв бохирдсон тохиолдолд нарийвчилсан судалгаа хийж бохирдлыг бууруулах, саармагжуулах арга

замуудыг хэрэгжүүлэх

- Уурхайн шинээр хөндөгдөх талбайн шимт хөрс хуулалт, хадгалалтад MNS 5916:2008 стандартыг баримтлан ажиллах
- Шимт хөрсийг ТЭЗҮ-д тусгасны дагуу уулын ажлын төлөвлөгөөнд тусгаж зохих талбайд хуулж хадгалах
- Шимт хөрсийг ажлын явцад шууд хэрэглэхгүй тохиолдолд тусгай талбайд үржил шимт чанарыг алдагдуулахгүйгээр хадгалах
- Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь шимт хөрсний хадгалалт, хамгаалалт, тордолтын бүртгэл, хяналтыг тогтмол хийж овоолгоос улиралд 1 удаа хөрсний үржил шимт чанарын шинжилгээ хийнэ.
- Тээврийн хэрэгслийн шатах тослох материал алдагдан хөрсөнд нэвчиж хүнд металлын бохирдол үүсэхээс сэргийлж байнгын хяналт шинжилгээ хийж зөвшөөрөгдсөн шаардлага хангасан тээврийн хэрэгслийг уурхайд ашиглах,
- Уурхайн дотоод, гадаад тээвэрлэлтийг тогтоосон маршрутаар зорчуулах, хурдны дээд хязгаарыг мөрдөх,
- Олборлолтын үйл ажиллагаагаар эвдрэлд өртсөн талбайд MNS 5917:2008 стандартын дагуу нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэн байнгын арчилгаа тордолт, мониторингийн ажлыг гүйцэтгэн орон нутагт хүлээлгэн өгөх,
- Ажилчдыг уурхай орчмын эрүүл талбайг хөндөхгүй, бохирдол үүсгэхгүй байхыг анхааруулж хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх талаар зөвлөмж өгч ажиллах,
- Зайлшгүй шаардлагатайгаас бусад газрын хөрс, ургамлыг эрүүл байлгах, зам жим гаргахгүй байх, явган хүний замаар зорчуулах, явган хүний зориулалтын замаас өөр маршрутаар зорчихгүй байхыг анхааруулах санамж тэмдэг тавих,
- Хог хаягдлын менежментийн зөвлөмжийг хэрэгжүүлэх.

3.4. Гадаргын болон газрын доорх ус

Төслийн талбайн ойролцоо гадаргын ил урсацтай гол, горхи байхгүй. Уурхай нь өөрийн эзэмшлийн 2 гүний худгаас усны хэрэглээгээ хангана. Иймд газрын доорх усыг зөв зохистой ашиглах, усны чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах зорилгоор төсөл хэрэгжүүлэгч дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Ус хангамжийн эх үүсвэр гүний худгийн паспортыг өрөмдсөн усны эрх бүхий мэргэжлийн байгууллагаар бүрэн гүйцэт бөглүүлэх
- Зам, талбайн тоосжилт дарах болон ногоон байгууламжийн усалгаанд хур борооны ус хуримтлуулан ашиглаж, усны нөөцийг хэмнэж ажиллах, ахуйн хэрэглээний усыг ариг гамтай хэрэглэж хэвшүүлэх
- Төсөл хэрэгжиж буй хугацаанд “Усны тухай” хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, 24.4, 28 дугаар зүйлийн 28.4, 28.6, 28.8, 30 дугаар зүйлийн 30.1 дахь хэсгүүдийн дагуу үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллах,
- Ус ашиглуулах дүгнэлтийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газраар гаргуулах,
- Ус ашиглах зөвшөөрлийг Говь-Алтай аймгийн БОАЖГ-аас авч гэрээ байгуулан ажиллах,
- Уурхайн ажилчдын ундны ус нь MNS 0900:2018 “ХБО. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус, Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” стандартын шаардлагыг хангасан байх,
- Ундны усыг хадгалах, хэмнэлттэй зарцуулах, усны бохирдлыг бууруулах боломжийг бүрдүүлж ажиллах
- Шингэн хаягдал зайлуулах шугамын бүтэн байдал алдагдсанаас хөрсөөр дамжин гүний усыг бохирдуулах

- Хог хаягдлыг ил задгай хаяснаар хөрсөөр дамжин гүний ус нянгийн бохирдолтод өртөх

3.4. Ургамлан нөмрөг

“Хөшөөтийн сайрын ордын “ХШ-6-ХШ-14”-ийн хооронд дахь алтны шороон ордыг ил аргаар ашиглах” уурхайн талбайд 1 ургамлын бүлгэмдэлд 12 овгийн 21 төрлийн нийт 26 зүйл ургамал ургасан байна. Төслийн үйл ажиллагаанаас 7.2 га талбайн байгалийн ургамлын хэв шинжээ алдагдаж нөлөөлөлд өртөхөөр байна.

Төсөл хэрэгжүүлэгч нь Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд Говь-Алтай аймгийн Засаг даргын тамгын газраас тарих модны тоо хэмжээ, байршлыг тогтоолгон 1200 ширхэг чацарганы суулгац тариалахаар санал авсан байна.

Хөрсний эвдрэл, автомашины хөдөлгөөнийг багасгаснаар ургамал амьтанд нөлөөлж болзошгүй нөлөөллийн хамрах хүрээг багасгах бүрэн боломжтой юм.

- Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн заасан талбайд 1200 ш модыг тариалан арчлан хамгаалах,
- Уурхайн эвдрэлд өртсөн талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэхэд MNS 5918:2023 стандартын техникийн шаардлагад нийцүүлэн гүйцэтгэх,
- Төсөл хэрэгжиж буй талбайн нутаг дэвсгэрийн онцлогтой уялдуулан ногоон байгууламж, нөхөн сэргээлтэд ашиглах ургамалжилтыг сонгон тариалах,
- Үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтыг бууруулах арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх,
- Уурхайн нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн ажлыг мэргэжлийн байгууллага эсвэл мэргэжилтнээр гүйцэтгүүлэн арчлалтын ажилд заавар, зөвлөгөө авч хэрэгжүүлэх шаардлагатай.
- Биологийн нөхөн сэргээлтэд тарих олон наст, үетэн, буурцагтан ургамлын зүйлийн сонголт хийх зөвлөмжөөс ашиглан тариалах

3.5. Амьтны аймаг

Төслийн талбай нь Говь-Алтай аймаг нь амьтны аймгийн хувьд газарзүйн мужлалаар Хойд говийн тойрогт багтана. Уурхайн үйл ажиллагаанаас хөхтөн амьтдад шууд устгах, агнах нөлөөлөл үзүүлэхгүй ч амьдрах орчныг хомсдуулах шууд нөлөөлөл үзүүлж байна. Харин шууд бус нөлөөлөлд дуу чимээ, агаарын бохирдол зэрэг хамаарна. Цаашид төслийн үйл ажиллагааны явцад дараах сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

- Төслийн талбай, түүний орчимд амьдардаг амьтдыг агнах, үргэх зэрэг санаатай үйлдэл гаргахаас сэргийлж уурхайн дотоод журамд энэ талаар заалт тусган тогтмол зөвлөмж, анхааруулга өгөх,
- Тээврийн хэрэгслийг тогтсон маршрутаар зорчуулан хурдны хязгаарыг тогтоох,
- Төслийн талбай руу зорчих зам дагуу амьтдын нүүдэллэдэг жим байгаа эсэхийг тогтоон тэмдэгжүүлэлт хийх,
- Уурхайтай ойролцоо нутаглах иргэдээс амьтдын хамгаалал, мал сүргийн бэлчээрлэлтийн талаар судалгаа авч аливаа санал ирвэл харилцан шийдвэрлэж байх,
- Уурхайн идэвхтэй олборлолтын талбайд мал, амьтан унаж бэртэх эрсдэлээс сэргийлэн хашаа хаалтын бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгах,
- Төслийн үйл ажиллагааг аль болох өдрийн цагаар /7-22 цаг/ олон тоног төхөөрөмж зэрэг ажиллуулахгүй байх зарчмыг баримтлан ажиллах шаардлагатай.

3.6. Нийгэм эдийн засаг

Орон нутгийн иргэдэд үзүүлэх нөлөөллийг бууруулах зөвлөмж

“Хос кварц” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Хөшөөтийн сайрын ордын “ХШ-6-ХШ-14”-ийн хооронд дахь алтны шороон ордыг ил аргаар ашиглах” нь Говь-Алтай аймгийн Тайшир сумын 2-р багт байрлана. Тус сум нь 2022 оны жилийн эцсийн мэдээллээр 5414 иргэн бүртгэлтэй байна.

- Олборлолт, тээвэрлэлт, баяжуулалтын үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтоос иргэдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхөөс сэргийлж тоосжилт бууруулах усалгаа болон бусад арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх,
- Нутгийн иргэдэд нээлттэй үйл ажиллагааг явуулж уурхайлалттай холбоотой мэдээлэл тогтмол танилцуулж санал авч харилцан шийдвэрлэдэг байх,
- Ажиллах 2 сарын хугацаандаа орон нутгийн иргэдээс ажлын байраар хангах,

Эдийн засагт үзүүлэх нөлөөллийг бууруулах зөвлөмж

- Уурхайн бүхий л үйл ажиллагаанд аюулгүй байдлыг хангаж ажиллах,
- Ажилчдыг эрүүл шим тэжээллэг хоол хүнсээр хангах,
- Аюулгүй байдлыг хангах хувцас хэрэглэлээр тогтмол хангах, ашиглалтын талаар дадлагыг тогтмол хийх,
- Нийт ажилчдад болон уурхайн бүсэд нэвтэрч буй иргэн бүрд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны заавар, зөвлөгөөг өгч нэвтрүүлэн аливаа эрсдэл бий болохоос сэргийлэх,
- Орон нутгийн ажилгүй иргэдийг ажлын байраар дадлагажуулан мэргэжлийн сургалтад хамруулан авч ажиллуулах,
- Ашигт малтмал олборлолт, ашиглалттай холбоотой бүхий л татвар, шимтгэлийг тухайн татварын албанд төлж барагдуулах,
- Орон нутгийн иргэдээс ажилчдын боломжит хоол хүнсний хэрэглээг авах
- Олборлолтыг зохих стандарт, хууль, журамд нийцүүлэн чанартай хийж гүйцэтгэн гэнэтийн аливаа эрсдэл үүсэхээс сэргийлэх, бэлэн байдалд үйл ажиллагааг явуулах шаардлагатай.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгад зааснаар аливаа төслийг хэрэгжүүлэхдээ байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд үндэслэн түүнийг гүйцэтгэсэн мэргэжлийн байгууллага үнэлгээний эрх бүхий аж ахуйн нэгж боловсруулан, улмаар төсөл хэрэгжүүлэгчтэй зөвшилцөн, ерөнхий үнэлгээг хийсэн байгууллагаар хянуулах, батлагдсаны дараа хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг хүлээсэн.

Иймд 2026 онд мэргэжлийн эрх бүхий “Маргад Очирваань” ХХК-иар боловсруулсан менежментийн төлөвлөгөөний дагуу 2026 онд хэрэгжүүлэх арга хэмжээг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах, хянан батлах журмыг баримтлан боловсруулав.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төслийн 2026 оны менежментийн төлөвлөгөөний ажилд нийт **512,508,420** төгрөг зарцуулахаар төсөвлөв.

Хүснэгт 10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

Зардлын хэлбэр	2026 он	Нийт зардал, (төгрөг)
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	55,960,000	55,960,000
Нөхөн сэргээлт, хаалтын төлөвлөгөөний зардал	270,630,100	270,630,100
Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зардал	21,818,320	21,818,320
Түүх археологийн дурсгал хамгаалах	50,000,000	50,000,000
Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	18,660,000	18,660,000
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	26,040,000	26,040,000
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал	20,000,000	20,000,000
Ногоон байгууламж, тарималжуулалт	17,400,000	17,400,000
Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	32,000,000	32,000,000
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах	-	-
НИЙТ	512,508,420	512,508,420

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТАЙШИР СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ХӨШӨӨТИЙН САЙРЫН АЛТНЫ ШОРООН ОРДЫН “ХШ-6-ХШ-14”-ИЙН ХООРОНД ДАХЬ НӨӨЦИЙГ ИЛ АРГААР АШИГЛАХ” ТӨСӨЛ

4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

Хүснэгт 11. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Давтамж	Хэмжих нэгж	2026	Нэгжийн үнэлгээ, төгрөг	Нийт зардал, төгрөг	Баримтлах хууль, журам, стандарт
АГААР ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ								
Хөрс хуулалт, газар шорооны ажлаас тоос их хэмжээгээр үүсэх	10 м/с-ээс дээш салхитай үед газар шорооны ажлыг зогсоох; замын усалгааг тогтмол хийх	Ил уурхайн дотоод тээврийн зам	(8, 9-р сард)	Удаа	3,000,000	Алтайн Өвөр Говийн сав газрын хэмжээнд ашигласан усны төлбөрийг холбогдох журмын дагуу тооцож барагдуулах	3,000,000	Агаарын тухай хууль MNS 4585:2025 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5013:2009 Байгалийн нөөц ашигласаны төлбөр Усны тухай хууль
Машин механизмаас утаа ялгарах	Тээврийн хэрэгслийн техникийн үзлэгийг уурхайн олборлолт эхлэхээс өмнө хамруулсан эсэхийг шалгах, хамруулах	Ил уурхайд ашиглагдах тээврийн хэрэгсэл бүрийг бүрэн үзлэг, оношлогоонд хамруулах (Үндсэн тээврийн хэрэгслийн тоо-8 ширхэг)	Ашиглалтын өмнө 7-р сард	ш	800,000	100,000	800,000	
Ажилчдын ахуйн хог, агаар бохирдуулах	Ажлын байр, түүний орчимд агаарт дэгдэж байгаа бохирдуулагч бодисыг тогтмол хэмжих суурин багаж суурилуулах	Ажилчдын хотхон, оффис байрлуулах	Ашиглалтын өмнө 7-р сард	2 ширхэг	3,600,000	1,800,000	3,600,000	
Нийт					7,400,000	4,900,000	7,400,000	
УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ								

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТАЙШИР СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ХӨШӨӨТИЙН САЙРЫН АЛТНЫ ШОРООН ОРДЫН “ХШ-6-ХШ-14”-ИЙН ХООРОНД ДАХЬ НӨӨЦИЙГ ИЛ АРГААР АШИГЛАХ” ТӨСӨЛ

Усны менежментийн алдаанаас нөөц хомсдох	Усны хэрэглээг эргүүлэн ашиглах боломжтой ус дахин боловсруулах боломжтой зөөврийн цэвэрлэх байгууламж суурьлуулах	Ажилчдын хотхон	Ашиглалтын өмнө (7-р сард)	1 ширхэг	10,000,000	5,000,000	10,000,000	“Усны тухай хууль” “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам” “Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль” MNS 0899:2020 MNS 0900:2018 MNS 6561:2015
Газар доорх шугам хоолой гэмтэж ус нэвчих	Шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн байнгын хяналт, засвар үйлчилгээг хийж гүйцэтгэж байх	Үйл ажиллагааны турш шаардлагатай шаардлагатай газар бүрт	2026 оны 7-р сараас 12-р сар	Сар бүр тогтмол	3,000,000	500,000	3,000,000	
Нийт					13,000,000	5,500,000	13,000,000	
ХӨРСӨН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ								
Газрын гадарга эвдэгдэх, доройтох	Шимт хөрсийг стандартын дагуу хуулж, хадгалах	Ил уурхайн олборлолт эхлэх үед	Ашиглалтын үед (8 дугаар сард)	11.0м³ шимт хөрс	24,200,000	2,000,000	24,200,000	MNS 5914:2008 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн нэр томьёо, тодорхойлолт MNS 5924:2015 Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага Хаягдал усны шаардлага MNS 4943:2015 MNS 6561:2015
ШТМ асгаралтаас хөрс бохирдох	ШТМ-ийн асгарсан тохиолдолд саармагжуулах хэрэгсэл бүрэн байлгаж, хяналтыг сайжруулж ажиллах	Тээврийн хэрэгслүүдийн зогсоолын талбай, ШТС, засварын газар	Ашиглалтын өмнө (7-р сард)	3 багц	3,600,000	1,200,000	3,600,000	
Засвар үйлчилгээний талбай дахь хөрсөн бүрхэвч бохирдох	Засвар үйлчилгээний талбайд бохирдсон алчуур, тосны шүүлтүүр, техникийн хаягдлыг түр хадгалах зориулалтын сав байрлуулах	Машин техникийн засвар, үйлчилгээний талбай	Ашиглалтын өмнө (7-р сард)	1 багц	600,000	600,000	600,000	
Нийт					27,800,000	3,200,000	27,800,000	
УРГАМЛАН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ								

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТАЙШИР СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ХӨШӨӨТИЙН САЙРЫН АЛТНЫ ШОРООН ОРДЫН “ХШ-6-ХШ-14”-ИЙН ХООРОНД ДАХЬ НӨӨЦИЙГ ИЛ АРГААР АШИГЛАХ” ТӨСӨЛ

Тоосжилт, машин техникээс шалтгаалан ургамлан нөмрөг доройтох	ШТМ шингээх зориулалтын материал (Spill Station Oil & Fuel Spill Kit)-ыг бэлэн байлгаж ШТМ асгарсан тохиолдолд ашиглан тархалтыг хязгаарлах	Тээврийн хэрэгслүүдийн зогсоолын талбай болон ШТС, засварын газруудад бэлэн байдлыг хангаж ажиллах	Ашиглалтын өмнөх шат (7-р сард)	4 ширхэг	2,400,000	600,000	2,400,000	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль ЗГ-ын 2021.11.17-ний өдрийн 350-р тогтоолоор батлагдсан Ургамал хамгааллын тухай хууль Газрын тухай хууль Хог хаягдлын тухай хууль MNS 5344:2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага
Төслийн талбайн ойр орчим бохирдох, ургамлан нөмрөг талхлагдах	Төслийн талбайн ойр орчмын цэвэрлэгээг тогтмол хийж, бүртгэл хөтлөж ажиллах	Төслийн талбайн хүрээнд	7 хоног тутамд	20 удаа	4,000,000	200,000	4,000,000	
	Шимт хөрсний овоолгыг нөхөн сэргээлтэнд ашиглахаас өмнө дээж шинжлүүлсэний дараагаар ашиглах (агрохими, хүнд металл)	Шимт хөрсний овоолго	Хаалтын үе (10-сард)	2 цэгээс 2 удаа	160,000	80,000	160,000	
Нийт					6,560,000	880,000	6,560,000	
АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ								
Хууль бусаар ан агнуур хийх	Ажилчид болон төсөлтэй холбоотойгоор төслийн талбайд ирэх хүмүүст хууль бус ан агнуурын тухай сануулга өгч, хууль тогтоомжийг танилцуулж ан агнуур хийлгэхгүй байх арга хэмжээг авч ажиллах	Уурхайд ажиллах нийт ажилтнуудад сургалт зохион байгуулах	Сар бүр тогтмол сургалт зохион байгуулах	6 удаа	1,200,000	200,000	1,200,000	Амьтны тухай хууль Байгаль орчныг хамгаалах тухай
Нийт					1,200,000	200,000	1,200,000	
Нийт дүн					55,960,000	6,100,000	55,960,000	

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТАЙШИР СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ХӨШӨӨТИЙН САЙРЫН АЛТНЫ ШОРООН ОРДЫН “ХШ-6-ХШ-14”-ИЙН ХООРОНД ДАХЬ НӨӨЦИЙГ ИЛ АРГААР АШИГЛАХ” ТӨСӨЛ

4.2. Нөхөн сэргээлт, хаалтын ажлын төлөвлөгөө

Хүснэгт 12. Нөхөн сэргээлт, хаалтын ажлын зардал

№	Ажлын нэр	Зардал, төг
1	Дүйцүүлэн хамгаалах ажлын зардал	-
2	Техникийн нөхөн сэргээлтийн зардал	131,147,100
2.2	Магадлашгүй зардал, 10%	14,571,900
3	Биологийн нөхөн сэргээлтийн зардал	88,512,600
3.1	Бордооны зардал	10,266,000
3.2	Ургамлын үрний зардал	6,400,000
3.3	Магадлашгүй зардал, 10%	8,046,600
4	Төслийн хаалтын зардал	10,300,000
5	Хаалтын дараах мониторингийн зардал	26,100,000
6	Байгаль орчин хамгаалах болон уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн нийт зардал	270,630,100

4.3. Дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөө

Хүснэгт 13. Дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөө

№	Үйл ажиллагааны төлөвлөгөө	Үр дүн
	Хийгдэх ажлууд	
1	Улс, орон нутгийн тусгай хамгаалалттай газарт биотехникийн арга хэмжээ авах, амьтан ажиглах камер байршуулах	Тусгай хамгаалалттай газарт орон нутгийн байгаль орчны газрын санал болгосны дагуу зэрлэг амьтдын байршил, тоо толгойг ажиглах хяналтын камер байршуулах, өвс тэжээл, хужир тавьж биотехникийн арга хэмжээ авч амьтдын тоо толгой өсөлтийн судалгаа явуулахад дэмжлэг үзүүлэх.
2	Аймгийн хэмжээнд хамгаалалтад авах шаардлагатай булаг шанд,	Усны онцгой хамгаалалтын бүсийг хамгаалалтад авах, хашаалах, тэмдэг тэмдэглэгээ тавих зэрэг ажлуудыг гүйцэтгэнэ.
3	рашааны эхийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх	Ундны усны чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор усны чанарын судалгаа хийлгэх
Нийт зардал, \$/жил		6115\$ ~ 21,818,320

4.4. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Хүснэгт 14. Орчны тохижилт, ногоон байгууламжийн төлөвлөгөө

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлт ийн зорилт	Үйл ажиллагааны арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Хэмжих нэгж	2026	Нэгжийн зардал, (төгрөг)	Нийт зардал (төгрөг)	Баримтлах стандарт, аргачлал
Тэрбум мод	Чацаргана модны суулгац	Говь-Алтай аймгийн Тайшир сумын ЗДТГ-аас санал авч заагдсан	ширхэг	1,200 ширхэг	10,000	12,000,000	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
	Модны био бордоо (биогул)		литр	300 литр	8,000	2,400,000	

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТАЙШИР СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ХӨШӨӨТИЙН САЙРЫН АЛТНЫ ШОРООН ОРДЫН “ХШ-6-ХШ-14”-ИЙН ХООРОНД ДАХЬ НӨӨЦИЙГ ИЛ АРГААР АШИГЛАХ” ТӨСӨЛ

	Хөрс, хөх бууц	газарт ногоон байгууламж, тарималжуулалтын ажлыг хийж гүйцэтгэх	тн	20 тн	3,000	3,000,000	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай
Орчны тохижилт цэцэрлэгжүүлэлтийн нийт зардал				17,400,000	21,000	17,400,000	

4.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

“Хос кварц” ХХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайд байгалийн болон түүх соёлын дурсгалт зүйл байхгүй. Төсөл хэрэгжих явцад талбайгаас түүх соёлын олдвор илэрсэн тохиолдолд үйл ажиллагааг зогсоон мэргэжлийн байгууллагад мэдэгдэж “Соёлын өвийг хамгаалах тухай” хуулийн дагуу шийдвэрлэнэ.

Хүснэгт 15. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Хэмжих нэгж	2026	Нэгжийн зардал, төгрөг	Нийт зардал, төгрөг	Баримтлах стандарт, аргачлал
Түүх, соёлын өвийг авран хамгаалах Түүх, соёлын өвийг авран хамгаалах	Төслийн барилгын ажлын үед түүх соёлын үл хөдлөх дурсгал илэрсэн тохиолдолд авран хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Төслийн талбайд олборлолт эхлэх, олборлолтын үед болон хаалтын үе шатанд	-	50,000,000	-	50,000,000	Соёлын өвийг хамгаалах тухай хууль
Нийт				50,000,000	-	50,000,000	

4.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 16. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Давтамж	Хэрэгжүүлэх хугацаа	2026	Нэгжийн зардал (төгрөг)	Нийт зардал (төгрөг)	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт
БАЙГАЛИЙН АЮУЛ, ГАМШИГ										
1	Гамшиг	Ажилчдын дунд газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх болон гамшгийн үеийн авран хамгаалах сургалт зохион байгуулах, мэдээллийн самбар байршуулах	Ажилчдын хотхон болон оффист	2 ширхэг	7-сард	Ашиглалтын эхэн үе шатанд	500,000	250,000	500,000	Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар, МУ-ын Шадар сайдын 120 тоот тушаал, 2018.12.07

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТАЙШИР СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ХӨШӨӨТИЙН САЙРЫН АЛТНЫ ШОРООН ОРДЫН “ХШ-6-ХШ-14”-ИЙН ХООРОНД ДАХЬ НӨӨЦИЙГ ИЛ АРГААР АШИГЛАХ” ТӨСӨЛ

2	Үер	Хур бороо, шар усны үерийн урсцын тооцоо судалгаанд үндэслэн үерийн хамгаалалтын далан, суваг шуудуу, усны байгууламжийг төлөвлөж барих, үерийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах	Ил уурхайн барилга, байгууламжийг үерийн аюулаас сэргийлж далан, шуудуу барих	Шаардлагатай байршил бүрт	7-сард	Ашиглалтын эхэн үе шатанд	360,000	120,000	360,000	ХАБЭА-н бодлого, заавар журам, стандарт
3	Ажилчид бэртэж, гэмтэх	Ажилчдын ажлын байрны нөхцөлтэй нь уялдуулан аюулгүй ажиллагааны, хувцас, хамгаалах хэрэгслээр хангах	Нийт ажилчидийг хувцас, хамгаалах хэрэгслээр бүрэн хангах	44 ширхэг	7-р сард	Ашиглалтын эхэн үе шатанд	15,400,000	350,000	15,400,000	ХАБЭА-н бодлого, заавар журам, стандарт, Хөдөлмөрийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль
5	Осол, аваар	Ажлын байрны онцлогтой нь холбогдсон осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх сургалт семинарыг зохион байгуулах	ХАБЭА-н сургалтыг зохион байгуулах,	2 сард 1 удаа	7, 9, 11-р саруудад	Ашиглалтын өмнөх, ашиглалтын үед, хаалтын үе шат эхлэх бүрт	600,000	200,000	600,000	
6	Гал түймэр	Болзошгүй галын аюулын үед ашиглах гал унтраах хэрэгсэл, материалыг шаардлагатай газар бэлэн байлгах, хугацаа дууссан тухай бүр шинэчлэх	Ажилчдын хотхон, оффис, баяжуулах үйлдвэр, засварын төв	4 ширхэг (иж бүрэн)	7-р сард	Ашиглалтын эхэн үе шатанд	1,800,000	450,000	1,800,000	Үйлдвэрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа, журам, галын аюулгүй байдлын тухай хууль
Нийт							18,660,000	-	18,660,000	

4.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 17. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТАЙШИР СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ХӨШӨӨТИЙН САЙРЫН АЛТНЫ ШОРООН ОРДЫН “ХШ-6-ХШ-14”-ИЙН ХООРОНД ДАХЬ НӨӨЦИЙГ ИЛ АРГААР АШИГЛАХ” ТӨСӨЛ

Хог хаягдлын төрөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Давтамж	Хэрэгжүүлэх хугацаа	2026	Нэгж зардал (төгрөг)	Нийт зардал (төгрөг)	Баримтлах хууль журам, стандарт, аргачлал
Ахуйн хатуу хог хаягдал	Ахуйн хатуу хог хаягдлын дээвэртэй түр цэг байгуулах. Энэ нь хог хаягдлыг ангилан ялгаж хаях боломжтой байх, хаягжуулсан байх	Хог хаягдлыг ангилан ялгах боломжтой, дээвэртэй, хогийн савыг төслийн талбайд байршуулах	2 иж бүрэн	7-р сард	Ашиглалтын өмнөх үе шат	5,000,000	2,500,000	5,000,000	“Хог хаягдлын тухай хууль” MNS 5344:2011 БОАЖС-ын 2018 оны А/428 дугаар тушаалаар батлагдсан “Хог хаягдлын улсын тоо бүртгэл хөтлөх, тайлагнах журам” Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар 10.2.3, 10.2.4
	Эдэлбэр газар, түүний эргэн тойрны хариуцан хамгаалах талбайн цэвэрлэгээг хийх	Төслийн талбайд	7 хоног бүрт тогтмол	20 удаа	Ашиглалтын өмнөх, ашиглалтын үед, уурхайн хаалт хийгдэх хүртэл	4,000,000	200,000	4,000,000	
	Хог хаягдлын цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх, орчныг бохирдуулахаас сэргийлж ойр орчмыг тогтмол цэвэрлэж байх	Нэгдсэн хог хаягдлын цэгт ариутгал халдваргүйжүүлэлтийг хийх	Сард 1 удаа	5 удаа	8, 9, 10, 11, 12-р саруудад	5,000,000	1,000,000	5,000,000	
Ахуйн шингэн хог хаягдал	Био-эко нойл суурьлуулан ашиглах	Төслийн хэмжээнд	2 ширхэг	7-р сард	Ашиглалтын өмнөх үе шатанд	6,000,000	3,000,000	6,000,000	
НИЙТ						20,000,000	-	20,000,000	

4.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

“Хос кварц” ХХК-ийн хэрэгжүүлж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчмийг харгалзан үзэж, түүний нөлөөллийн бүсийн талбайг хамруулан байгаль орчны хяналт шинжилгээний мониторингийн системийг байгуулах нь зүйтэй.

Тухайн төслийг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг “Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” /ОХШХ/ гэнэ.

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь төслийг хэрэгжүүлэх явцад үүссэн сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах үйл ажиллагаа ямар үр дүнтэй байгааг илтгэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа болон нутгийн оршин суугчдад бодитой мэдээлэл өгөхөд чухал ач холбогдолтой.

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТАЙШИР СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ХӨШӨӨТИЙН САЙРЫН АЛТНЫ ШОРООН ОРДЫН “ХШ-6-ХШ-14”-ИЙН ХООРОНД ДАХЬ НӨӨЦИЙГ ИЛ АРГААР АШИГЛАХ” ТӨСӨЛ


Хүснэгт 18. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр/Олборлолтын өмнө /

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хэмжих нэгж	Байршил		Хугацаа ба давтамж			Нэгж зардал (төгрөг)	Нийт зардал (төгрөг)	Хамтран хэрэгжүүлэгч	Баримтлах стандарт
1. АГААРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ											
1.1	- Агаарын тоос тоосонцор (TSP, PM ₁₀)	мкг/м ³	Төслийн талбай <i>Нийт 5 цэгт</i>		Олборлолтын өмнө (7 сард)	Олборлолтын үед	Олборлолтын дараах үе	60.0	7.850.0	Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатори	MNS 4585:2025 MNS 3384:1982 MNS 4048:1988 MNS 0017-2-5-11:1988 MNS 5013:2009 MNS 5014:2009
2. УСНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ											
2.1	- Ерөнхий химийн шинжилгээ	мг/дм ³	Унд-ахуйн ус	Гүний худаг <i>1 цэгт</i>	Олборлолтын өмнө (7 сард)	Олборлолтын үед	Олборлолтын дараах үе	60.5	1.061.0	Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатори	MNS (ISO) 5667-1:2002 MNS (ISO) 5667-2:2002 MNS 0900:2018
	- Хаягдал бохир усны шинж	мг/дм ³	Хаягдал ус		Олборлолтын өмнө (7 сард)	Олборлолтын үед	Олборлолтын дараах үе	80.0	3.089.		
3. ХӨРСНИЙ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ											
3.1	- Хөрсний агрохимийн үндсэн үзүүлэлтүүд	мг/кг	Ашиглалтын талбай	<i>Нийт 5 цэгт</i>	Олборлолтын өмнө (7 сард)	Олборлолтын үед	Олборлолтын дараах үе	40.0	14.440.0	“Грийн лаб” хөрс судлалын лаборатори	MNS 3298-90 MNS 2305:94 MNS 5850-2023 MNS 3310-91
	- Хөрсний хүнд элементүүд /Pb, Cr, Cd, Ni, Co, Cu/			<i>Нийт 5 цэгт</i>		Олборлолтын үед	Олборлолтын дараах үе				
Нийт									26.040.000		

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТАЙШИР СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ХӨШӨӨТИЙН САЙРЫН АЛТНЫ ШОРООН ОРДЫН “ХШ-6-ХШ-14”-ИЙН ХООРОНД ДАХЬ НӨӨЦИЙГ ИЛ АРГААР АШИГЛАХ” ТӨСӨЛ

Хүснэгт 19. Орчны хяналт шинжилгээний цэгийн байршил

Шинжилгээ хийх байршил		х	у
Агаар	Талбайн хойд цэгт	96.470413°	46.298742°
Дуу шуугиан	Талбайн урд цэгээс	96.471201°	46.294750°
Хөрс	Байгалийн хөрс /хяналтын цэг/	96.457272°	46.294086°
	Эвдрэлд өртсөн хөрс	96.460252°	46.299952°
Ус	Төслийн талбайд байрлах худгаас	96.454051°	46.294139°



Зураг 4. Мониторингийн цэгийн байршлын зураг

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТАЙШИР СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ХӨШӨӨТИЙН САЙРЫН АЛТНЫ ШОРООН ОРДЫН “ХШ-6-ХШ-14”-ИЙН ХООРОНД ДАХЬ НӨӨЦИЙГ ИЛ АРГААР АШИГЛАХ” ТӨСӨЛ

4.9. Байгаль орчны удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 20. Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	2026	Нэгж зардал, (төгрөг)	Нийт зардал, (төгрөг)	Баримтлах хууль, журам, стандарт
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, үр дүнг тайлагнах	Төслийн хэмжээнд	Удаа/жилд	12,000,000	12,000,000	12,000,000	Байгаль хамгаалах тухай хууль
Байгаль орчны төлөвлөгөөт аудит хийлгэх	Төслийн хаалтын үед	Хаалтын үед	15,000,000	15,000,000	15,000,000	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
Сэргээгдэх эрчим хүч ашиглаж уурхайн хотхоны гадна талбайн гэрэлтүүлгийг шийдэх	Ажилчдын хотхон, оффисын зам талбайд	50 ширхэг	5,000,000	100,000	5,000,000	БОАЖ-ын сайдын 2019.10.29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” Усны тухай хууль
Нийт			32,000,000	-	32,000,000	

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТАЙШИР СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ХӨШӨӨТИЙН САЙРЫН АЛТНЫ ШОРООН ОРДЫН “ХШ-6-ХШ-14”-ИЙН ХООРОНД ДАХЬ НӨӨЦИЙГ ИЛ АРГААР АШИГЛАХ” ТӨСӨЛ

4.10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 21. БОМТ хэрэгжилт тайлагнах арга хэмжээний төлөвлөгөө

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцаж зохион байгуулах албан тушаалтан
1	Аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газраар хянуулж БОУАӨЯ-аар батлуулах	www.eic.mn цахим хэлбэрээр	Тухайн жилийн БОМТ-ийн биелэлтийн тайлан	Жил бүрийн 11-р сарын 1-ний дотор	Үйл ажиллагааны зардал	Удирдлага Ерөнхий инженер Хариуцсан ажилтан
2	Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар -Асуудал хариуцсан мэргэжилтэн -БО хяналтын байцаагч	Хуралд танилцуулах, Уулзалт зохион байгуулах	БОМТ-ийн тухайн жилийн тайлан, Ирэх оны төлөвлөгөө	12-р сарын 1-ний дотор		
3	Орон нутгийн иргэд					
4	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	Тайлан, төлөвлөгөөг www.eic.mn цахим хэлбэрээр	Төлөвлөгөөг хянуулан батлуулах	12-р сарын 20-ний дотор		

ДҮГНЭЛТ

“Хос Кварц” ХХК нь Говь-Алтай аймгийн Тайшир сумын нутагт “Хөшөөтийн сайрын алтны шороон ордын “ХШ-6-ХШ-14”-ийн хооронд дахь нөөцийг ил аргаар ашиглах” төсөл үйл ажиллагаагаа явуулж байна. Төслийн хүрээнд 2026 онд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардалд **512,508,420 төгрөг** ба үүнд 2026 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал, нөхөн сэргээлтийн зардал байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа зэрэг ажлын зардлууд багтсан болно.